

Жижиг, дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нэвтрүүлсний үр нөлөө

The Effect of Adopting for IFRS for SMEs

Д. Баттуяа¹, Д. Лхагвасүрэн², Л. Хишигбаяр³

Хураангуй

Манай улсад жижиг, дунд аж ахуйн нэгж (ЖДААН)-ийн санхүүгийн тайлагналын чанарыг дээшлүүлэх үүднээс ЖДААН-ийн санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ыг 2011 оноос нэвтрүүлж эхэлсэн. Энэ стандартын үр нөлөө, ач холбогдлыг үнэлэх зорилгоор 2014 онд 161, 2018 онд 222 ЖДААН дээр санхүүгийн тайлагналын чанарын хэмжигдэхүүнүүдийг ашиглан хэмжиж, стандарт нэвтрэлтийн үр нөлөө хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан судаллаа. Судалгааны явцад СТОУС нэвтрэлт зардал ихтэй, нягтлан бодогчдын бодит хэрэгцээнд тулгуурлан сургалтыг хангалттай зохион байгуулж чадахгүй байгаа нь ажиглагдсан. Мөн ЖДААН-үүдийн санхүүгийн тайлагналын стандартын нэвтрэлт хангалттай биш байгааг харуулж байна. ЖДААН-ийн СТОУС-ын нэвтрэлт нь 2014 ба 2018 оны хооронд сайжирсан үзүүлэлт харагдаж байгаа ч үнэн зөв байх хэмжигдэхүүний хувьд ач холбогдолтой ялгаа гараагүй. Энэ нь ЖДААН-үүд санхүүгийн тайлангаа үнэн зөв илэрхийлэхэд тодорхой хүчин зүйлийн нөлөөлөл байгааг харуулж байна. Иймд санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэн гаргах талаар илүү анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Түлхүүр үгс: СТОУС нэвтрэлт, санхүүгийн тайлангийн шинж чанар

Abstract

This study examines that the effect of the adoption of International Financial Reporting Standards (IFRS) by Small and Medium Enterprises (SMEs) in Mongolia in the reaction of the respondents of SMEs. Our data shows that the adoption of IFRS for SMEs is 41% of all SMEs. The feelings that IFRS is bad and stressful are the highest percentage of respondents. The highest percentage concerning the difficulties that were encountered at the first time adoption is 72% which says that IFRS has training difficulty and high cost. Our result is consistent with IFRS for the SMEs are costlier and any training can't meet the real needs of accountants (Bolormaa, 2014). Also, the result shows that the mean difference between SMEs adopted IFRS for SMEs and SMEs not adopted is significantly for understandability, comparability, timeliness, and relevance and insignificantly for faithful representation for SMEs. At last, the result shows that IFRS adoption improves the quality financial statement which is consistent with the "benefits of IFRS adoption".

Keywords: IFRS adoption, characteristics of financial statements

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш, доктор
E-mail: battuya.d@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш
E-mail: dlkhagva@num.edu.mn

³ МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш
E-mail: khishigbayar@num.edu.mn

Оршил

Улс орны эдийн засгийн хөгжилд ЖДААН-үүд нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Аж ахуйн нэгжийн НББ тайлагналд олон улсын стандартыг нэвтрүүлэх нь санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчид болох хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн шийдвэрт өндөр ач холбогдолтой. Стандарт нэвтэрсний үр дүнд санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар дээшилдэг (Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл - НББОУСЗ, 2009) гэж үздэг. Монгол улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"⁴-ийн дагуу 2016.01.01-нээс ЖДААН нь СТОУС-ыг дагаж мөрдөхөөр албан ёсоор хуульчилсан. Манай улс 2011 оноос эхлэн ЖДААН-ийн стандартыг нэвтрүүлэн энэ талаарх хэд хэдэн удаагийн сургалтыг аж ахуйн удирдлага болон нягтлан бодогчдод зохион байгуулсан ч хангалттай биш байгаа талаар дүгнэсэн байдаг (Болормаа, 2014). Иймд ЖДААН-ийн СТОУС-ын нэвтрүүлэлт эдгээр аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлагналын чанарт хэрхэн нөлөөлж байгааг үнэлсэн болно. Судалгааны үр дүн НББ-ийн бодлого тодорхойлогчдод туслалцаа үзүүлэх ач холбогдолтой.

Стандартын нэвтрэлтийн үр нөлөөг судалсан судалгаануудын дүгнэлтээс дурьдвал:

- Стандартыг нэвтрүүлснээр хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцаа холбоо сайжирч, санхүүгийн мэдээллийн алдаа буурдаг (Smith, 2001).
- Чанартай санхүүгийн тайлангийн мэдээлэл илүү хэрэглэгдэхүйц, ач холбогдолтой байдаг гэж баталсан (Abdallah, 2013).
- 21 улсын аж ахуйн нэгж дээр судалгаа

хийж, стандартыг нэвтрүүлснээр аж ахуйн нэгжийн орлого, зардлын уялдаа холбоо сайжирч, ашиг, алдагдлыг үнэн зөв илэрхийлдэг гэдгийг тогтоосон (Barth нар, 2008).

- Аккруэль загвар болон бусад загваруудыг ашиглан санхүүгийн тайлагналын чанарыг үнэлсэн (van Beest нар, 2009). Эдгээр загварууд нь тайлант хугацааны эцэс дэх санхүүгийн тайлангийн мэдээллийг ашиглан ашгийн удирдлагыг хэмжсэн байдаг.
- Монгол улсад ЖДААН-ийн стандартыг нэвтрүүлсэн байдлыг судалж, стандартыг нэвтрүүлэх судалгаа туршилтын ажил хангалттай хийгдээгүй, ЖДААН-ийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн журам, аргачлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж дүгнэжээ (Дариймаа, 2016).
- Монгол Улсын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компанийн санхүүгийн тайлангууд нь мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэхүйц байгааг хэмжих арга зүйг боловсруулсан (Гантулга, 2018).

Санхүүгийн тайлагналын шинж чанарын хэмжигдэхүүнүүдийг ашиглан олон судлаачид санхүүгийн тайланд СТОУС-ын нэвтрэлт хэр байгааг судалсан байдаг. (Гантулга, 2018).

Санхүүгийн тайлагналын шинж чанарын хэмжигдэхүүнүүдэд үндсэндээ уялдаа холбоотой байх, үнэн зөв байх, ойлгомжтой байх, харьцуулагдах, цаг хугацаандаа байх үзүүлэлт багтдаг. Ойлгомжтой байдал нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилсан, товч тодорхой илэрхийлсэн зэргээр тодорхойлогддог (НББОУХ, 2008). Өөрөөр хэлбэл, ойлгомжтой байдал гэдэг нь санхүүгийн тайлангийн

⁴ 2016 оны шинэчилсэн найруулга

мэдээллийг хэрэглэгчид ойлгох, унших чадвар (НББОУХ, 2008) юм. Ойлгомжтой байдлыг дараах байдлаар хэмжиж болно. Юуны өмнө санхүүгийн тайланг зөв зохион байгуулж, дансдыг зөв ангилснаар санхүүгийн тайланг уншиж ойлгоход хялбар байдаг (Jonas нар, 2000). Дараа нь тайлангуудын мэдээллүүдийг тодруулсан эсэхээр тодорхойлогдоно. Тодруулахдаа хүснэгт, график ашиглаж болно (НББОУХ, 2006). Мөн санхүүгийн тайланг бэлтгэхдээ энгийн үг, үгсийн тайлбарыг хэрэглэж тайлбарласнаар хэрэглэгчдэд ойлгоход илүү хялбар байдаг (Courtis, 2005). Харьцуулагдах байдлыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг (НБББББ)-ээ тогтвортой хэрэглэж байгаа эсэх болон аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн мэдээлэл бусад аж ахуйн нэгжийн мэдээлэлтэй харьцуулагдах боломжтой эсэхэд чиглэнэ. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, дүрэм журмын шинэ өөрчлөлт бүр нь аж ахуйн нэгжийн НБББББ, бүртгэлийн тооцооллод өөрчлөлт оруулахыг шаардаж байдаг. Энэхүү өөрчлөлтийг одоогийн бүртгэлдээ хэрхэн тусгасан, өмнөх үеийн санхүүгийн тайланг хэрхэн залруулсан талаар тайлбарлах нь харьцуулагдах байдалд мөн хамаатай. Учир нь тухайн аж ахуйн нэгжийн өмнөх тайлант хугацааны мэдээлэл нь одоогийн тайлант хугацааны мэдээлэлтэй харьцуулагдахын тулд ижил бүртгэлийн тооцооллыг ашигласан байх нь зүйтэй. Мэдээж өөр өөр тооцоолол, арга зүй бүхий санхүүгийн тайлангуудыг харьцуулах нь төвөгтэй. Харин хоёр өөр компанийн санхүүгийн мэдээллийг харьцуулж үзэхэд компаниудын үйл ажиллагааны чиглэл, НБББББ-тэй эсэх, ажил гүйлгээгээ тайлбарласан байдал зэрэг нь чухал нөлөөтэй. Цаг хугацаандаа байх ойлголт нь тохиромжтой цагт ач

холбогдолтой шийдвэр гаргахыг хэлдэг. Үнэн зөв байдлыг санхүүгийн тайлангийн мэдээлэл иж бүрэн, консерватив, материаллаг алдаагүй, анхан шатны баримтанд үндэслэсэн гэдгээр хэмжиж болно (Dechow нар, 1996). Энэ нь санхүүгийн тайланд алдаатай утга байгаа эсэхийг хянахдаа хэвийн бус тооцооллын өөрчлөлт гарсан эсэхийг харгалзана. Дараагийн чиглэл нь аж ахуйн нэгжийн сонгосон НББ-ийн зарчим нь үнэхээр алдааг илрүүлэхэд чиглэсэн эсэхийг хянана. Гурав дахь чиглэл нь консерватив байх. Консерватив байх гэдэг нь санхүүгийн тайланд эерэг болон сөрөг ажил гүйлгээг аль алиныг нь тэнцвэртэй оруулах явдал юм (Jonas нар, 2000). Дөрөв дэх чиглэл нь аудитын тайлангийн чанараар хэмжигдэнэ. Компанийн эдийн засгийн үнэ цэнээс хамаарч компанийн удирдлага аудитын тайланд нөлөөлөх магадлалтай гэдгийг олон судлаачид илрүүлсэн байдаг. Сүүлийн чиглэл нь үнэн зөв байдлыг компанийн засаглалтай холбон үздэг. Компанийн засаглалын тайлан нь санхүүгийн тайлангийн чанарт эерэгээр нөлөөлдөг төдийгүй хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Уялдаа холбоотой байх гэдэг нь тодорхой нөхцөлд олон хувилбараас сонголт хийх чадвар компани түүхэн өртгийн оронд бодит үнэ цэнэ хэрэглэдэг эсэхэд илүү хамаардаг.

Монголын ЖДААН-үүдийн санхүүгийн тайлагналын өнөөгийн байдал

"НББ-ийн тухай хууль"-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага нь стандартын дагуу аккруэль суурьт зарчмаар нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг. Жижиг болон дунд аж ахуйн нэгжийн хувьд стандартыг хялбарчилсан ЖДААН-ийн СТОУС-ыг 2011 оноос нэвтрүүлж эхэлсэн. Энэ стандартыг

нэвтрүүлэхтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн хуулийн шинэчилсэн найруулгаар ЖДААН-ийг дунд, жижиг, бичил аж ахуйн нэгж гэж ангилж; дунд, жижиг аж ахуйн нэгжийн хувьд ЖДААН-ийн СТОУС-ыг мөрдөхөөр заасан. “Аудитын тухай хууль”-иар жижиг, дунд аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх албагүй боловч аудитлагдсан санхүүгийн тайлан нь зээлдүүлэгчид болон хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлдэг байна. Дэлхийн банкны (2008) судалгаанаас харахад стандарт нэвтрэлт маш өндөр зардалтай, төвөгтэй тул Монголын ЖДААН СТОУС-ын дагуу тайлангаа толилуулдаггүй байна. Тухайлбал, татварын хуулинд заасан аргуудын хүрээнд санхүүгийн тайлангаа бэлтгэн толилуулах хандлагатай байгаа нь стандартын шаардлагад нийцдэггүй, энэ нь санхүүгийн тайлагналын чанарт сөргөөр нөлөөлж байна гэжээ.

Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ЖДААН-ийн тоо 2014 онд 50,932; 2018 оны 1-р улирлын байдлаар 69,264 байна. Бид ЖДААН-үүдийн СТОУС-ын нэвтрэлтийн байдал, түүнийг хэрхэн сайжруулах талаар 2014 онд 161 ЖДААН дээр судалгаа хийсэн. 2018 онд ЖДААН-үүдийн СТОУС-ын нэвтрэлтийн байдал, үр нөлөө хэрхэн өөрчлөгдсөнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулах зорилгоор 2018 онд 222 аж ахуйн нэгжийг түүвэрлэн авч судалгаа хийсэн. Судалгааг van Beest нарын (2009) судалгааны асуулгын загварыг ашиглан хийсэн ба санхүүгийн тайлангийн хэмжигдэхүүнүүдэд харгалзах асуултыг тавьж, асуулт тус бүрт 1-3 оноог өгч дүгнэсэн.

Хүснэгт 1-ийн А хэсэгт судалгаанд хамрагдсан ЖДААН-үүдийг мэдээллийн дагуу салбараар нь ангилсан. 2014 онд судалгаанд хамрагдагсдын 55.9%, 2018

Хүснэгт 1: Түүвэр судалгаа

А хэсэг: Салбарын ангилал

№	Салбар	2014		2018	
		ЖДААН тоо	Хувь	ЖДААН тоо	Хувь
1	Барилгын салбар	6	3.7%	25	11.3%
2	Худалдааны салбар	49	30.4%	77	34.7%
3	Үйлчилгээний салбар	41	25.5%	75	33.8%
4	Ноос, ноолуур, хөнгөн үйлдвэр	5	3.1%	8	3.6%
5	Тээврийн салбар	6	3.7%	4	1.8%
6	Үйлдвэрлэл	9	5.6%	22	9.9%
7	Хөдөө аж ахуй	10	6.2%	7	3.2%
8	Бусад	35	21.7%	4	1.8%
Нийт дүн		161	100%	222	100%

Жич: Өмнөх судалгааны салбарын ангиллыг ашиглав.

Б хэсэг: ЖДААН-ийн ажилчдын мэдээлэл

№	Ажилчдын тоо	ЖДААН тоо	Хувь	ЖДААН тоо	Хувь
1	1-9	38	23.6%	85	38.3%
2	10-19	63	39.1%	75	33.8%
3	20-149	41	25.5%	40	18.0%
4	150-аас дээш	19	11.8%	22	9.9%
Нийт дүн		161	100%	222	100%

Жич: Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн дагуу ангилсан.

В хэсэг: ЖДААН-ийн борлуулалтын орлогын мэдээлэл

№	Борлуулалтын орлого, төгрөг	ЖДААН тоо	Хувь	ЖДААН тоо	Хувь
1	100 саяас бага	74	46.0%	69	31.1%
2	101 – 500 сая	64	39.8%	90	40.5%
3	501 саяас дээш	23	14.3%	63	28.4%

Жич: Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн дагуу ангилсан.

Г хэсэг: ЖДААН-ийн СТОУС нэвтрэлт

№	ЖДААН-ийн СТОУС нэвтрэлт	ЖДААН тоо	Хувь	ЖДААН тоо	Хувь
1	Нэвтэрсэн	66	41.0%	93	41.9%
2	Нэвтрээгүй	95	59.0%	129	58.1%

Жич: Өмнөх судалгааны ангилал ашигласан.

Д хэсэг: ЖДААН-ийн СТОУС хэрэглэсэн мэдрэмж

№	ЖДААН-ийн СТОУС хэрэглэсэн мэдрэмж	ЖДААН тоо	Хувь	ЖДААН тоо	Хувь
1	Муу, хэцүү	12	18.2%	3	3.2%
2	Төвөгтэй	30	45.5%	48	51.6%
3	Ялгаагүй	9	13.6%	42	45.2%
Нийт дүн		66	100%	93	100%

Жич: Өмнөх судалгааны ангилал ашигласан.

Е хэсэг: ЖДААН-ийн СТОУС анх нэвтрүүлсэн мэдрэмж

№	ЖДААН-ийн СТОУС-ыг анх нэвтрүүлэх үед ямар байсан бэ?	ЖДААН тоо	Хувь	ЖДААН тоо	Хувь
1	Сургалт муу, төвөгтэй	20	30.3%	34	36.6%
2	Маш их зардалтай	28	42.4%	8	8.6%
3	Хэтэрхий их ажиллагаатай	13	19.7%	26	28.0%
4	Бусад хүчин зүйлс	5	7.6%	25	26.9%
Нийт дүн		66	100%	93	100%

Жич: Өмнөх судалгааны ангилал ашигласан.

Ё хэсэг: Сургалтанд хамрагдсан байдал

№	Стандартын сургалтанд хамрагдсан уу?	ЖДААН тоо	Хувь	ЖДААН тоо	Хувь
1	Тийм	51	32.1%	84	37.8%
2	Үгүй	108	67.9%	138	62.2%
Нийт дүн		159	100%	222	100%

Жич: Өмнөх судалгааны ангилал ашигласан.

онд 68.5% нь худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж байна. "Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль"⁵-ийн дагуу ажилчдын тоо болон борлуулалтын орлогоор нь ангилахад судалгаанд хамрагдагсдын 46.0% нь бичил⁶ аж ахуйн нэгжид хамрагдаж байна. Г хэсэгт стандарт нэвтрүүлсэн байдлыг авч үзэхэд 2014 онд ЖДААН-үүдийн 41.0% буюу 66

нь нэвтрүүлсэн. 2014 онтой харьцуулахад 2018 онд стандарт нэвтрэлтийн байдал бараг 1%-иар нэмэгдсэн байна. Энэ нь ЖДААН-ийн стандарт нэвтрүүлэлтэд багч ч болтугай ахиц гарсаныг харуулж байна. Д хэсэгт 2014 оны судалгаагаар стандарт нэвтрүүлсэн аж ахуйн нэгжүүдийн 63.7% нь стандарт нэвтрэлт төвөгтэй, хэцүү, бэрхшээлтэй, Е хэсэгт 30.3% нь энэ

⁵ ЖДҮ-ийг дэмжих зорилгоор энэхүү хуулийг баталсан.

⁶ 10-аас доош ажилчидтай, 10 саяас доош борлуулалтын орлоготой бол бичил ангилалд хамаарна.

стандартыг анх нэвтрүүлэхэд сургалтыг сайн зохион байгуулаагүй, 42.4% нь стандарт нэвтрүүлэх нь зардал ихтэй гэж хариулж байсан бол 2018 онд стандарт нэвтрүүлэлтийн төвөгтэй, бэрхшээлтэй байдал 8.9%, зардал өртгийн хэмжээ 33.8%-иар тус тус буурсан байна. 2011 онд ЖДААН-ийн СТОУС-ыг нэвтрүүлснээс хойш стандартын сургалтыг хэд хэдэн удаа зохион байгуулсан боловч 2014 онд судалгаанд хамрагдагсдын 67.9% нь сургалтанд суугаагүй байсан бол 2018 онд сургалтанд хамрагдагсдын тоо бараг 6 хувиар өссөн байна. Иймээс стандартын сургалтыг чанартай, үе шаттайгаар зохион байгуулах нь стандартыг нэвтрүүлэхэд ач холбогдолтой гэж хэлж болохоор байна.

Хүснэгт 2-т санхүүгийн тайлагналын чанарын хэмжүүрүүд болох ойлгомжтой

Хүснэгт 2: Санхүүгийн тайлагналын шинж чанарын үзүүлэлтүүд

Асуултууд	2014		2018	
	Дундаж	Стандарт хазайлт	Дундаж	Стандарт хазайлт
Ойлгомжтой байх				
Жилийн санхүүгийн тайлангаа сайн зохион байгуулж чаддаг уу? (Тодруулах шаардлагатай зүйлсийг тодруулж, хүснэгт, графикаар тайлбарладаг эсэх)?	1.35	0.59	2.73	0.51
Харьцуулагдах байдал				
НБББББ-ын өөрчлөлт гарвал тодруулж, тооцооллын өөрчлөлт гарвал өмнөх үеийн тайлангаа залруулдаг уу?	2.12	0.60	2.10	0.94
Тодруулга тайлбарлаж, НБББББ байнга ашигладаг уу?				
Цаг хугацаандаа байх				
Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хугацаанд тайлангаа тушаадаг уу?	1.43	0.68	2.79	0.38
Үнэн зөв байх				
Жилийн санхүүгийн тайлангаа гаргахдаа тооцоололдоо бодит утга ашигладаг уу?	1.33	0.58	2.63	0.58
НББНХЗЗ-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн утгаа сонгодог уу?				
Уялдаа холбоотой байх				
Компанийн ирээдүйн шийдвэр гаргалтанд зориулан төсөвлөсөн санхүүгийн тайлан гаргадаг уу?	1.73	0.84	1.84	0.99
Түүхэн өртгийн оронд бодит үнэ цэнэ хэрэглэдэг үү?				

Жич: Асуулт бүрт 3 хариулт өгсөн ба хариулт бүрт харгалзах оноог өгсөн. Тухайлбал, тийм бол 3 оноо, дундах хариулт 2 оноо, үгүй гэсэн бол 1 оноо.

⁷ НББ-ийн хуульд зааснаар жилийн санхүүгийн тайланг дараа оны 2 сарын 10-нд тушаана.

Хүснэгт 3: Санхүүгийн тайлагналын шинж чанарын үзүүлэлтийн дундажийн ялгаа

Үзүүлэлтүүд	2014			2018		
	ЖДААН-ийн СТОУС нэвтрүүлсэн mean, n=66	ЖДААН-ийн СТОУС нэвтрүүлээгүй mean, n=95	t-test	ЖДААН-ийн СТОУС нэвтрүүлсэн mean, n=93	ЖДААН-ийн СТОУС нэвтрүүлээгүй mean, n=129	t-test
Ойлгомжтой байх	1.53	1.23	3.218 ***	2.89	2.62	3.992 ***
Харьцуулагдах байдал	2.21	2.00	1.817 **	2.32	1.93	3.103 ***
Цаг хугацаандаа байх	1.66	1.19	4.482 ***	2.86	2.81	2.358 **
Үнэн зөв байх	1.37	1.23	1.630	2.69	2.63	1.454
Уялдаа холбоотой байх	1.97	1.51	5.039 ***	2.01	1.82	2.139 ***

гарлаа. Цаг хугацаандаа байх үзүүлэлт 1.43-с 1.84 байгаа нь тайланг хоцроох явдал буурсан гэдгийг харуулж байна. Дээрхээс дүгнэж үзвэл 2014 оноос 2018 оны судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүүгийн тайлагналын шинж чанарын үзүүлэлт сайжирсныг харуулж байна.

Хүснэгт 3-т ЖДААН-ийн СТОУС нэвтрэлтийн байдалд санхүүгийн тайлангийн шинж чанарын үзүүлэлтүүдийн дундажийн ялгааг авч үзсэн. 2014 онд ойлгомжтой байх, харьцуулагдах, цаг хугацаандаа байх, уялдаа холбоотой байх гэсэн чанарын хэмжигдэхүүнүүд нь статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байсан бол санхүүгийн тайлангийн үнэн зөв байх чанарын үзүүлэлтийн ялгаа ач холбогдолгүй гарсан. Өөрөөр хэлбэл, санхүүгийн тайланг бэлтгэхэд үнэн зөв байх тухай ойлголт төдийлөн сайжрахгүй хандлагатай байгаа ба санхүүгийн тайланг үнэн зөвөөр илэрхийлэхэд ямар нэг өөр хүчин зүйлс нөлөөлдөг гэдэг нь харагдаж байна. Энэ нь магадгүй санхүүгийн тайланг татварын хуулийн дагуу татварын зорилгоор татварын албанд зориулан бэлтгэдэгтэй холбоотой байж болох юм.

Дүгнэлт

Энэхүү судалгаа нь ЖДААН-д СТОУС-ын нэвтрэлтийн ач холбогдлыг үнэлэх зорилготой байлаа. Судалгаанд 2014 онд үйл ажиллагаа явуулж байгаа 161 ЖДААН-ийг хамруулахад 41.0% нь жижиг, дундад зориулсан стандартыг нэвтрүүлсэн байсан бөгөөд стандарт нэвтрүүлсэн аж ахуйн нэгжүүдийн 72.7% нь стандарт нэвтрүүлэлт маш их төвөгтэй, бүртгэл хөтлөхөд хэцүү, стандартыг нэвтрүүлэх нь зардал ихтэй гэж хариулсан. Харин 2018 оны байдлаар 222 ЖДААН-ийг хамруулан судлахад 41.9% нь стандартыг нэвтрүүлсэн байсан. ЖДААН-ийн СТОУС-ын нэвтрэлт нь санхүүгийн тайлангийн чанарт эерэгээр нөлөөлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан тул түүнийг нэвтрүүлснээр гарах давуу талыг тухайн аж ахуйн нэгжийн удирдлага, нягтлан бодогчдод сурталчлан таниулж, уян хатан нөхцөл бүхий сургалт зохион байгуулах нь зохистой юм. Судалгаанаас харахад ЖДААН-ийн СТОУС-ыг нэвтрүүлэх үйл ажиллагаа удаан байгаа боловч стандартыг нэвтрүүлсэн ААН-үүдийн хувьд харьцангуй сайн үзүүлэлтийг харуулж байна.

Ашигласан материал

1. Abdallah, A. A. J. (2013). The Impact of Using Accounting Information Systems on the Quality of Financial Statements Submitted to the Income and Sales Tax Department in Jordan. *European Scientific Journal*, 1, 41-48.
2. Ball, R., Kothari, S. P., & Robin, A. (2000). The Effect of International Institutional Factors on Properties of Accounting Earnings. *Journal of Accounting and Economics*, 29(1), 1-51.
3. Barth, M. E., Landsman, W. R., & Lang, M. H. (2008). International Accounting Standards and Accounting Quality. *Journal of Accounting Research*, 46(3), 467-498.
4. Brochet, F., Jagolinzer, A. D., & Riedl, E. J. (2013). Mandatory IFRS Adoption and Financial Statement Comparability. *Contemporary Accounting Research*, 30(4), 1373-1400.
5. Bushman, R. M., & Smith, A. J. (2001). Financial Accounting Information and Corporate Governance. *Journal of Accounting and Economics*, 32(1-3), 237-333.
6. Clarkson, P., Hanna, J. D., Richardson, G. D., & Thompson, R. (2011). The Impact of IFRS Adoption on Value Relevance of Book Value and Earnings. *Journal of Contemporary Accounting and Economics*, 7(1), 1-17.
7. Dechow, P. M., Sloan, R. G., & Hutton, A. P. (1996). Causes and Consequences of Earnings Manipulation: An Analysis of Firms Subject to Enforcement Actions by the SEC. *Contemporary Accounting Research*, 13(1), 1-36.
8. IASB & FASB (2006, 2008, 2009). *Conceptual Framework for Financial Reporting*.
9. International Federation of Accountants (2004). Challenges and Successes in Implementing International Standards: Achieving Convergence to IFRSs and ISAs
10. Jonas, G. J., & Blanchet, J. (2000). Assessing Quality of Financial Reporting. *Accounting Horizons*, 14(3), 353-363.
11. Muturi, N. (2009). A Survey Study of the Financial Challenges Faced by Small and Micro Enterprises in Nairobi - A Case Study of Motor Vehicle Repair Garages in Nairobi. MBA Project Paper, University of Nairobi, 2009
12. Sloan, R. G. (2001). Financial Accounting and Corporate Governance: A Discussion, *Journal of Accounting and Economics*, 32(1-3), 335-347.
13. van Beest, F., Braam, G., & Boelens, S. (2009). *Quality of Financial Reporting: measuring qualitative characteristics*. NiCE Working Paper 09-108.
14. Болормаа, Б. (2014). *ААНБ-ын санхүүгийн тайлагналд олон улсын стандартыг нэвтрүүлэх зарим асуудал*, диссертацийн ажил.
15. Гантулга, Г. (2018). *Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг үнэлэх нь*, диссертацийн ажил.
16. Дэлхийн банк (2008). Монголын нягтлан бодох бүртгэл, аудит.
17. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, 2007.
18. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2015.
19. Монголын хөдөлмөрийн яам (2013). Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн гарын авлага.